

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АРХИВЫН ТАСАГ

АРХИВЫН ТАНИЛЦУУЛГА

Сүхбаатар хот

2016 он

## ГАРЧИГ

1. ӨМНӨХ ҮГ.....	1
2. I ХЭСЭГ АРХИВЫН ТАНИЛЦУУЛГА.....	
3. II ХЭСЭГ СЭЛЭНГЭ АЙМГИЙН АРХИВЫН ТАСГИЙН ТОВЧ ТҮҮХ.....	
4. III ХЭСЭГ АРХИВЫН ТАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	
5. IIII ХЭСЭГ САН ХӨМРӨГИЙН ТАЛААР.....	
6. V ХЭСЭГ СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН АРХИВЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	
7. ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	
8. НОМ ЗҮЙ .....	
9. ХАВСРАЛТ.....	

## Өмнөх үг

Төрийн архивын сан хөмрөгийн нэгдсэн танилцуулга боловсруулан гаргах, улсын бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, ажил хэрэг болгож буй нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, хүргэж байгаа мэдээллийн үнэ цэнэ, байгууллагын нээлттэй, шуурхай үйл ажиллагаагаар дүгнэдэг болж буй энэ цаг үед цаг үеэ олсон ажил болж гэж үзэж, бүрэн дэмжиж хүлээн авч байна. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлэх төрийн албан хэрэг хөтлөлтийн эмх цэгцтэй боловсронгуй болгох” зорилт дэвшүүлснээр архивын салбарын хөгжлийн ойрын чиг хандлагыг тодорхойлсон гэж үздэг.

Түүнчлэн Үндэсний Архивын газрын 2000-2004 онд дэвшүүлсэн үйл ажиллагааны зорилтын хүрээнд хийгдэж буй энэхүү үр дүнд тус аймгийн болон Архивын тасгийн түүх, Архивын тасгийн үйл ажиллагаа, чиг үүрэг, иргэд байгууллагад үзүүлэх үйлчилгээний чиглэл, дээд шатны болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад нийлүүлэх бүтээгдэхүүний анги, тавигдах шаардлага зэргийг тодорхойллоо.

Цаашид Үндэсний Архивын газраас гаргах нэгдсэн танилцуулга, мэдээллийн сангийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Архивын газрын танилцуулга, түүхэн товчооныг хэвлүүлж оны хүртээл болгох зорилттой байна.

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### Архивын танилцуулга

БНМАУ-ын Засгийн газраас тус улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны хуваарилалтыг өөрчлөн тогтооход 1931 онд Тариалангийн аймаг нэртэйгээр байгуулагдан төв Аптанбулаг хотод аймгийн Яамыг төвлөрүүлэн байгуулахаар болжээ. Сайд нарын Зөвлөлийн 1932 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 21 дүгээр хурлын тогтоолоор аймгийн нэрийг Сэлэнгэ аймаг болгох шийдвэр гаргажээ.

Тус аймаг нь Монгол орны умард хэсэгт Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө голын үзэсгэлэнт сав газар, ойт хээрийн бүсэд оршдог. Хойт талаараа Оросын Холбооны Улс, баруун талаараа Булган, өмнө талаараа Төв, зүүн талаараа Хэнтий аймагтай тус тус хил залгаж, дундаа Дархан- уул аймгийг агуулдаг.

Нийт 43.0 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, бүх нутгийн 42.3 хувийг ой мод, 47 хувийг бэлчээр, 7.3 хувийг хадлангийн талбай эзэлдэг. Одоогийн байдлаар 107.6 мянган хун амтай. Аймгийн **төв Сүхбаатар хот \_\_ мянган** хүн амтай. Улаанбаатар хотоос 335 км зайд оршдог. Тус аймаг 17 сум, 6 тосгон, орон нутгийн 3 хоттой.

Монгол улсын Архивын тухай хуулинд төрийн архивын тогтолцоо нь Үндэсний төв болон аймаг, нийслэлийн архиваас бүрдэнэ хэмээн заасан байдаг билээ. Иймд дээрх архивууд нь тухайн оршин буй нутагт дэвсгэртээ (түүхэн үнэ цэнэ бүхий баримтаар сан хөмрөгөө нөхөн бүрдүүлж, эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг зохих горимын дагуу хийж гүйцэтгэх, хадгалагдаж буй баримтыг хэвлэл мэдээллийн болон бусад хэлбэрээр олон нийтийн хүртээл болгон ашиглуулах ) үндсэн үүрэгтэй.

БНМАУ-ын СнЗ-ийн 1958 оны 176 дугаар тогтоолд "БНМАУ-ын архивын хэргийг төвлөрүүлж, түүний хадгалалтыг сайжруулж, архивын баримт материалыг улс нийгэм, соёл, шинжлэх ухааныг хөгжүүлэх сонирхлын үүднээс ашиглах явдлыг хангахын тулд аймаг, хотын улсын архивт төвлөрүүлэн, улсын архивын нэгдсэн фондыг байгуулсугай" гэж зааснаар аймгуудын архивын эх суурь тавигдсан билээ. Тухайн үед Сэлэнгэ аймаг татан буугдаж Булган, Төв аймгуудад нэгдсэн байсан бөгөөд одоогоор тус архивт 1956-1959 онд хамаарах хүн, мал тооллогын "А" дансууд хадгалагдаж байна.

**ХОЁРДУГААР ХЭСЭГ****АРХИВЫН ТОВЧ ТҮҮХ**

1959 онд Сэлэнгэ аймаг дахин байгуулагдахад аймгийн ХДХ-ын Гүйцэтгэх захиргааны Зохион зааварлах хэлтсийн бүрэлдэхүүнд оруулахаар заасны дагуу аймгийн ХДХ-ын Гүйцэтгэх захиргааны 1960 оны 08 дугаар захирамжаар байгуулж, эрхлэгчээр нь Ерөө суманд НАХЯ-ны төлөөлөгчөөр ажиллаж байсан Б.Пүрэвжавыг архивын эрхлэгчээр томилсон байна. 1992 оныг хүртэл энэ зохион байгуулалтаар ажиллаж ирсэн бөгөөд тухайн онд батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу шинэчилэн зохион байгуулагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын Засаг захиргааны хэлтэст харъяалагдахаар болжээ. Тухайн үед манай улс эдийн засаг, нийгмийн шинэ тогтолцоонд шилжин улсын үйлдвэрийн газар, сангийн аж ахуйнууд хувьчлагдах болон татан буугдаж эхэлсэн тул Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын даргын болон Хууль зүйн сайдын хамтран гаргасан 1992 оны 10/124 тоот тушаалын дагуу тэдгээр байгууллагуудад хадгалагдаж байсан архивын баримтуудыг эмхлэн цэгцэлж, аймгийн Улсын архивт шилжүүлэн авах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий 1992-1994 онд архивын дэргэд аж ахуйн тооцоот группыг байгуулжээ. Монгол улсын Засгийн газрын 1998 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор төрийн архивын харъяаллыг өөрчилсний дагуу аймгийн Засаг даргын 1998 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 247 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн харъяа Архивын тасаг болгон зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 164 дүгээр тогтоолоор “Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтын дүрэм” батлагдсанаар аймгийн тасгийн дарга нь архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагчийн эрхийг хэрэгжүүлж ажиллах болсон байна. Монгол улсын Засгийн газрын 2007 оны 25 дугаар тогтоолоор Архивын алба болон өөрчлөгдөж, харъяаллын хувьд аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст харъяалагдан үйл ажиллагаагаа явуулж байгаад 2008 оны 67 дугаар тогтоолоор Архивын тасаг болон Хууль зүйн хэлтсийн харъяанд шилжсэн. 2006 онд Монгол Улсын Засгийн газраас баталсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үүрэг чиглэл бүхий гэрээт ажилтнуудыг ажиллуулах тухай Засгийн газрын 2010 оны 261 дүгээр тогтоолын дагуу 2011 оноос Архивын тасгийн дэргэд 5 гэрээт ажилтныг ажиллуулж эхэлсэн. Тус архиваас олон улсын архивын байгууллагад гишүүнээр элсэх

тухай хүсэлтийг Олон улсын Архивын зөвлөлийн Зүүн Азийн орнуудын архивын салбар зөвлөл / EASTICA /-д хүргүүлэн 2012 онд “С” зэрэглэлийн гишүүнээр элссэн.

Архивын тасаг нь дарга, сан хөмрөгийн эрхлэгч, архивч гэсэн үндсэн орон тоотой, архивч-операторч гэсэн гэрээт 5 ажилтантайгаар Нутгийн захиргааны III байранд үйл ажиллагаа явуулж байна. Тус архивын анхны эрхлэгч Б.Пүрэвжав гэдэг хүн байсан бөгөөд 1961 оныг хүртэл ажиллажээ. Үүнээс хойш архивын эрхлэгч, Улсын архивын эрхлэгч, Архивын тасгийн даргаар

Д.Данзан / 1961-1976 он /

Х.Должинпунцаг /1976-1984 /

Ш.Батсүх / 1984-1991 /

Г.Баасанжав / 1991-1993 /

З.Хишигжаргал / 1993-2016 он / нар тус тус ажиллаж байсан.

## ГУРАВДУГААР ХЭСЭГ

### АРХИВЫН ТАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Архивын тасаг нь Монгол улсын Архивын тухай хууль, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, холбогдох тогтоол, зааврыг мөрдлөг болгон ажилладаг. 1998 онд батлагдсан Архивын тухай хуулиар сан хөмрөгийн бүрэлдэхүүн, баримт бичгийн өмчийн хэлбэр, төрийн архивын үйл ажиллагааны үндсэн зарчим, тогтолцоо, эрх үүрэг нь хуульчлагдсанаар архивын үйл ажиллагааны эрх зүйн үндэс баталгаажсан болно. Анх байгуулагдсан үеэс буюу 1960 оноос тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны байгууллагууд болон үйлдвэр, сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдэл, албан байгууллагуудын баримтаар сан хөмрөгөө нөхөн бүрдүүлж иржээ.

Тус Архивын тасаг нь архивын баримтыг хуульд заасан журмын дагуу байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан баримтыг хүлээн авч хадгалж хамгаалах, зориулалтын дагуу ашиглуулах ажлын хүрээнд 17 сум, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23 байгууллага, төрийн 68, төрийн өмчийн оролцоотой 7 УУГ болон ОНӨААТҮГ зэрэг нийт 114 байгууллагын архивын баримт материалыг хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгээд байна.

Архивын тасаг нийт 3 өрөөнд үйл ажиллагаа явуулдаг ба хадгаламжийн сангийн өрөөний аюулгүй байдал, стандартын шаардлагыг бүрэн хангасан агааржуулалтын

систем, орчин үеийн дохиоллын систем, галын хор болон бусад хамгаалалтын хэрэгсэлтэй.

Мөн архивын баримтыг “Төрийн архивын сан хөмрөгийг ашиглуулах журам”-ын дагуу байгууллага, иргэдэд үйлчилж, лавлагаа мэдээлэл гарган өгч судалгаанд өргөн ашиглуулдаг.

Орон нутагт албан хэрэг хөтлөлтийн стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлэхийн тулд дараах ажлуудыг хийж байна. Үүнд:

-Албан ажлын хэрэгцээнд хэвлэмэл хуудас захиалж хэрэглэх

-Байгууллагын үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдөх баримт бичгийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргаж баталгаажуулах

-Бичиг хэрэгт заавал бүртгэх, албан тушаалтан хянан батлах, тэмга тэмдгээр баталгаажуулж байх баримт бичгийн жагсаалтыг гарган мөрдөх;

-Баримт бичгийн шинэ стандартыг нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудаар судлуулах, сургалт зохион байгуулах, холбогдох гарын авлага, зөвлөмжөөр хангах;

-Тус аймгийн төрийн захиргааны байгууллагуудаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний үндсэн чиглэлд архивын чиглэлээр үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг тогтоон өгөх зэрэг ажлуудыг дурьдаж болно.

## **ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ**

### **САН ХӨМРӨГИЙН ТАЛААР**

Одоогоор тус архив нь 3 хадгаламжийн сантай бөгөөд үүнд 126 хөмрөгийн 30000 гаруй хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Нөхөн бүрдүүлэлтийн ажлыг батлагдсан хуваарийн дагуу явуулж ирсэн бөгөөд 1992 онд САА, үйлдвэр албан газрууд татан буугдахад тэдгээрийн баримтыг Дээрхи хугацаанд нийт хөмрөгийн 70 гаруй хувийг уг ажлын үеэр шинээр байгуулсан байна. Мөн УИХ -ын 1998 оны 04 тоот тогтоолд заасны дагуу аймгийн МАХН -ын хорооны 1931 - 1990 оныг хүртэлхи үеийн баримт болох 7000 гаруй ХН-ийг архивт хүлээн авч сан хөмрөгт байршуулжээ.

Тус архив эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдол бүхий нөхөн бүрдүүлэлт хийх, тэдгээрийг олж илрүүлэх зэрэг ажлыг орон нутгийн судлаачидтай хамтран зохион байгуулж байна.

- Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 50, 60, 70 жилийн ойн холбогдолтой баримт бичгүүд
- Сэлэнгэ аймгийг 1960 онд дахин байгуулсан тухай Улсын комиссын баримт бичгүүд
- Орос Монголын ард түмний эрт үеэс уламжлал болгон тэмдэглэж ирсэн Эв модны наамын тухай 1980-2002 оны түүвэр материал зэрэг материалуудаар сан хөмрөгөө баяжуулсан.

Тус архивын баримтын бүрэлдэхүүний хувьд аймгийн ХДХ-ын Гүйцэтгэх захиргааны болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тогтоол, захирамж, албан даалгавар, аймгийн Засаг даргын Тамгын газрын болон төрийн байгууллага, үйлдвэр, аж ахуйн газрын даргын тушаал, хүн амын ба мал тооллогын бүртгэлүүд, хурлын тэмдэглэл, ажлын тайлан, төлөвлөгөө, мэдээ, гүйцэтгэлийн баримтууд, удирдах ажилтны ажил хүлээлцсэн тухай акт зэрэг зохион байгуулалтын баримт бичгүүд, тус аймагт баригдаж ашиглалтанд орсон барилгуудын ажлын зураг төсөв / аймгийн ЗДТГ-ын барилга, Гурилын комбинатын элеваторуудын зураг / байна. Үүн дээр нэмж аймгийн хэмжээнд явагдсан өмч хувьчлалын холбогдолтой материалыг дурьдаж болно.

Архивын хосгүй үнэт баримтыг илрүүлэх ажлыг нягтлан шалгалтын ажлын явцад явуулж Аугаа их Эх орны дайны үед Зөвлөлтийн Улаан Армид бэлэг цуглуулах үүрэг гүйцэтгэж байсан аймгийн Бэлэглэлийн комиссын тайлан мэдээ, бусад баримт бичгүүд, ардын хувьсгалын журамт цэргүүдийн дурсамж яриа, Сэлэнгэ аймаг байгуулагдах үеийн түүхэнд холбогдох дурсамж ярилцлагууд, тус аймагт хурж байсан сүм хийд, лам нарын бүртгэл зэрэг баримт бичгүүдийг хосгүй үнэт баримтад тавигдах шалгуурын дагуу нягтлан шалгаж бүртгэл үйлдээд байна.

Баримтын ашиглалтын талаар дурьдвал иргэд байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу тэдэнд шаардлагатай байгаа архивын баримтыг ашиглуулахын зэрэгцээ эрдэм шинжилгээ судалгааны ажилд мөн ашиглуулж байна. Тухайлбал Ө.Бавуу “Сэлэнгийн түүхэн товчоон” / 2001 /, Л.Банзрагч “Сэлэнгэ нутгийн XX зууны түүхийг бүтээлцэгчид” / 2004 / 2011 онд тэмдэглэн өнгөрүүлсэн аймгийн 80 жилийн ойд зориулан гаргасан “Хоймор нутгийн хийморь” 2 боть, аймгийн МАН-ын хорооны 80 жилийн түүхийн



эмхэтгэл зэрэг олон бүтээлүүдийг дурьдаж болно. Мөн 2014 онд үүсэн байгуулагдсанахаа 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн зарим сумдаас эрхлэн гаргасан түүхийн бүтээлүүд, зурагт альбомууд, CD зэрэг баримт бичгүүдийн нэг хувийг шилжүүлэн авсан.

Хадгалагдаж буй баримтууд нь ихэвчлэн цаасан суурьтай бөгөөд үлдсэн хувь нь гэрэл зургийн негатив хувиуд, CD-д буулгасан архивын баримтын ашиглалтын хувиуд байгаа болно. Мөн барилгын ажлын зураг зурагдсан тусгай төрлийн цаасан / кальк / баримтууд эзэлдэг.

Одоогоор тус архивт хадгалагдаж буй баримтууд нь 1931-2015 оныг хүртэлхи үеийг хамарч байгаа болно. 1956-1959 онд тус аймаг нь Төв, Булган аймгуудтай нэгдсэн байсан учир энэ үеийн баримтуудыг Төв, Булган аймгийн Төрийн архивт хүсэлт хүргүүлсний дагуу хуулбарлан авах, бүртгэл актаар шилжүүлэн авах ажлыг 2011, 2012 онуудад гүйцэтгэсэн. Мөн Дархан, Хонгор сумд нь засаг захиргааны өөрчлөлтөөр 1981 онд Дархан хотын мэдэлд шилжсэн тул дээрхи сумдын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны 1960-1980 оны баримтуудыг Дархан Уул аймгийн Төрийн архивт 2012 онд шилжүүлэн өгсөн.

### ТАВДУГААР ХЭСЭГ

#### СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН АРХИВЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. **Архивын нэр, код** Сэлэнгэ аймгийн Төрийн архив
2. **Эрхэм зорилго** Сэлэнгэ нутгийнхаа түүхийн эрдэнэсийн сан болсон архивын сан хөмрөгийн баримтыг хадгалж хамгаалах, нөхөн баяжуулах, сурталчлан дэлгэрүүлэх, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах, хойч үедээ бүрэн бүтэн өвлүүлэн үлдээхэд оршино.
3. **Алсын хараа** Орон нутгийн төр, захиргааны байгууллагуудын архивын баримтын тоо бүртгэл, мэдээлэл лавлагааны сан үүсгэх ажилд мэдээллийн технологийн дэвшлийг өргөн ашиглах, зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах, төрийн архивын үйл ажиллагааг хадгалалт хамгаалалтын аюулгүй байдлыг найдвартай хангаж чадахуйц орчин үеийн шаардлагад нийцсэн зориулалтын байранд эрхлэн явуулах.
4. **Зорилт** Архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцлийг сайжруулах, түүх, эрдэм шинжилгээний ач холбогдол бүхий баримтуудаар нөхөн бүрдүүлэлт хийж тэдгээрийг цахим хэлбэрт шилжүүлэн байгууллага, иргэдэд цахим үйлчилгээ үзүүлэх боломжийг хангах.

5. **Харъяалал** Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн Архивын тасаг
- 6.
7. **Орон тоо** 9
8. **Нийт /үндсэн болон гэрээт/ ажилтны тоо** Үндсэн ажилтан 4, гэрээт ажилтан 5
9. **Бүтэц зохион байгуулалт**

Зохион байгуулалтын нэгжийн нэр	Албан тушаалын нэр	Орон тоо
Аймгийн Архивын тасаг	Тасгийн дарга	1
	Сан хөмрөгийн эрхлэгч	1
	Архивч	1
	Мэдээллийн технологийн ажилтан	1
	Цахим сангийн операторч	2
	Архивч, операторч	3
<b>Нийт</b>		<b>9</b>

#### 9. Үйлчилгээний цагийн хуваарь

Гарчиг	Хугацаа	
Даваа	09.00-13.00	14.00-18.00
Мягмар	09.00-13.00	14.00-18.00
Лхагва	09.00-13.00	14.00-18.00
Пүрэв	09.00-13.00	14.00-18.00
Баасан	09.00-13.00	14.00-18.00
Бямба	Амарна	
Ням		

#### 10. Архивын албан ёсны хаяг :

- Зип код **213200**

- Аймаг, хотын нэр **Сэлэнгэ аймаг. Сүхбаатар сум**

- Гудамж талбайн нэр, дугаар **Г.Төмөрбаатарын гудамж**
- Байшин /өрөө, тасалгаа/-ийн дугаар **Нутгийн захиргааны 3-р байр № 09**
- Утас, Факсын дугаар **70363823**
- Архивын болон ажилтнуудын цахим шуудан /E-mail/-ийн хаяг
- Цахим хуудасны хаяг **www.Selenge archives.mn**
- Архивын онцлогоос шалтгаалж дээр дурьдсанаас бусад шаардлагатай мэдээллүүд

### Хоёр. Архивын түүхийн талаархи мэдээлэл

1. **Архивын үүсч байгуулагдсан огноо** 1960.01.15
2. **Архив байгуулсан шийдвэр** Сэлэнгэ аймгийн Хөдөлмөрчдийн депутатын хурлын Гүйцэтгэх захиргааны 1960 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 08 дугаар захирамж

### 3. Архивын нэрийн өөрчлөлт

Огноо	Нэрийн өөрчлөлт	Шийдвэрийн нэр, огноо, дугаар
1960.01.15	Сэлэнгэ аймгийн Улсын архив	Аймгийн ХДХГЗ-ны 1960.01.15-ны өдрийн 08 дугаар захирамж
1998.09.08	Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Архивын тасаг, аймгийн Төрийн архив	Сэлэнгэ аймгийн Засаг даргын 1998 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 247-р захирамж
2007.01	Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Архивын алба	Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 25 дугаар тогтоол
2008.12.24	Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Архивын тасаг	Монгол Улсын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 67 дугаар тогтоол

4. **Архивын түүхийн талаархи бусад мэдээлэл** /Архивын орон тоо бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, түүхэн хөгжил, он дарааллын хэлхээс/ Аймгийн Улсын архив гэсэн бүтэц зохион байгуулалтаар ажиллах байх үед нөхөн бүрдүүлэлтийн эх үүсвэрийн хувьд үйлдвэр, албан газар, сангийн ба тэжээлийн аж ахуй, нэгдэл зэрэг байгууллагууд байсан 1992 оноос өмч хувьчлалаар хувьчлагдсан сангийн ба тэжээлийн аж ахуйнууд, үйлдвэрүүд, татан буугдсан албан газруудын баримтуудыг шилжүүлэн авч эхэлсэн. Энэ ажлыг Улсын архивын дэргэдэх 4 хүнтэй аж ахуйн тооцоот группийн архивч нар 1992-1996 онуудад хийж гүйцэтгэсэн. Одоо тус архивын нөхөн бүрдүүлэлтийн эх үүсвэр өөрчлөгдөж сумдын ЗДТГ, газар, хэлтэс, албад болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаас байнга хадгалагдах баримтуудыг шилжүүлэн авч байна.
5. **Архивын талаархи бусад мэдээлэл** Тус тасаг нь баримтын хэмжээ эрс нэмэгдэж хадгаламжийн сангийн өрөө хүрэлцээгүй болсон тул 2005 оноос Нутгийн захиргааны

3-р байранд шилжин байрлаж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд одоо хадгаламжийн сангийн 3 өрөөтэй, тоног төхөөрөмжийн хувьд 16 нягтруулсан шүүгээ, галын аюулаас урьдчилан сэргийлэх багаж хэрэгслүүд, зөөврийн шат, баримт зөөх тэргэнцэрийг албан ажлын хэрэгцээнд ашиглаж байна.

### Гурав. Сан хөмрөгийн лавлах

#### 1. Хөмрөг үүсгэгчийн нийт тоо: Үүнээс

Төрийн байгууллага	Төрийн өмч оролцсон аж ахуйн нэгж	Улс төр нам	Олон нийтийн байгууллага	Төрийн бус бусад байгууллага	Шашны байгууллага	Хувийн хэвшлийн ахуйн нэгж	Хувь
106	3	1	1	1		2	3

#### 2. Хөмрөгийн нийт тоо: 126. Үүнээс:

Байгууллагын 107

Нэгдсэн

Хувийн хөмрөг 3

Цуглуулга хөмрөг 3

#### 3. Нийт дансны тоо

#### 4. Хадгалагдаж буй баримтын тоо хэмжээ: 30540.

Баримтын төрөл	Он цаг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт дүн	Тайлбар
Цаасан суурьтай баримт	1931-2014 он	ХН	30540		
Зураг төсөл баримт	2003-2015 он	ХН	741		
Дүрс бичлэгийн хуурцаг /VCHS/	1998-2011 он	Ширхэгээр	11		
		Минутаар	-		
Дуу авиа бичлэг /хуурцаг, кассет/	2005-2011 он	Ширхэгээр	27		
		Минутаар	1110		
Гэрэл зураг	2009-2011 он	Ширхэгээр	113		
Цомог	2010-2012	Ширхэгээр	3		
Бусад	-	-	-		

**5. Баримтын тойм:**

Хөмрөгийн бүрэлдэхүүний хувьд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал ба Засаг даргын тамгын газар, сумдын Засаг даргын Тамгын газрууд, газар, хэлтэс, албадын архивын баримтууд, хувьчлагдсан сангийн аж ахуй, үйлдвэрийн газруудын баримтуудын хадгалагдаж байгаагаас гадна татан буугдаж үйл ажиллагаа нь зогссон албан байгууллагууд, дээд газрын шийдвэрээр баримтыг нь шилжүүлэн авсан улс төрийн намын баримтууд мөн хадгалагдаж байна. Баримтын он цагийн хувьд 1931-2015 онд хамаарах бөгөөд нийт баримтын 90 орчим хувийг байгууллагын удирдлагын үйл ажиллагааны явцад үүсч бий болсон цаасан суурьтай баримтууд эзлэх бөгөөд үлдэх хувийг гэрэл зураг, дүрс бичлэгийн хуурцаг, зэрэг баримт бичгүүд эзэлж байна. Удирдлагын баримт бичгийн хувьд засаг захиргааны нэгжийн ба байгууллагын удирдлагаас гаргасан захирамж, тушаал, хөмрөгийн үүсгэгч байгууллагын хурлын тэмдэглэл, жилийн ажлын төлөвлөгөө тайлан, санхүүгийн жилийн эцсийн тайлан, 5 жилийн ажлын батлагдсан төлөвлөгөө, аймаг, сумын АДХ-ын чуулгануудын баримт бичиг зэргээс бүрдэнэ. Мөн улсын ба аймгийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламжуудын холбогдолтой зураг төслийн баримтууд хадгалагдаж байна. Мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2011 оноос цахим баримт үүсгэх ажлыг эхлүүлж одоогийн байдлаар ХН-ийн мастер хувийг багтаасан DVD

**6. Архивын сан хөмрөгт хадгалагдаж буй хосгүй үнэт, ховор нандин, үнэт баримтуудын тухай /тойм/**

Хосгүй үнэт баримтыг сонгон авахдаа Үндэсний архивын газрын даргын 2003 оны 10 дугаар тушаалаар батлагдсан журманд заасан шалгуурыг үндэс болгосон бөгөөд одоогоор 1943-2009 оны баримтуудыг оруулан бүртгээд байна. Бүрдлийн хувьд Сэлэнгэ аймгийн Партизан нарын 2,3 дугаар хурлуудын баримт бичиг, Зөвлөлтийн Улаан Армид туслах аймгийн Бэлэглэлийн салбар комиссын холбогдолтой баримт бичиг, “Монгол Ард” нисэх эскадрил байгуулахад Сэлэнгэ аймгийн хөдөлмөрчдөөс хандивласан мөнгөн болон бусад эд зүйлсийн дүн мэдээ, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэнүүдийн бичсэн Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошууны тухай дурьдатгал, 1939 оны Халх голын дайны ахмад дайчдын дурьдатгал, Сэлэнгэ аймгаас шагнагдсан Хөдөлмөрийн баатар болон гавъяат цолтнуудын Зарлигуудын эх болон хуулбар хувь зэрэг баримт бичгүүдээс бүрдэнэ.

**Нэмэлт мэдээлэл.** 2012 онд Олон улсын архивын зөвлөлийн Зүүн Азийн орнуудын архивын салбар зөвлөл /EASTICA/-д “С” зэрэглэлийн гишүүнээр элссэн.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

1. ЗДТГ – Засаг даргын Тамгын газар
2. АДХГЗ – Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаа
3. ҮАГ – Үндэсний Архивын газар
4. УҮГ – Улсын үйлдвэрийн газар

## НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Архивын тухай хууль 1998 он
2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр / 2000-2004 /
3. Сэлэнгэ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр / 2000- 2004 /
4. Сэлэнгэ аймгийн Засаг даргын захирамж 1998 он
5. Сэлэнгийн түүхэн товчоон СБ 2001 он
6. Архив албан хэрэг хөтлөлттэй холбогдсон хууль тогтоомжийн эмхэтгэл  
УБ хот 1999 он
7. Сэлэнгэ АЗДТГ-ын төрийн албан хаагчдын албан тушаалын карт
8. КЕМУ сэтгүүл дугаар № 1, № 2 2002 он
9. Архивын сан хөмрөгийн 1-р фонд
10. Архивын сан хөмрөгийн 2-р фонд
11. Архивын сан хөмрөгийн 3-р фонд